



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар A/622

Номгон

Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх  
төлөвлөгөө, Үнэлгээ хариуцсан менежерүүдийг  
чадавхжуулах хөтөлбөрийн зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 8/10 дугаар тогтоосл, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, Үнэлгээ хариуцсан менежерүүдийг чадавхжуулах хөтөлбөрийг хоёрдугаар, Төлөвлөгөө, хөтөлбөрийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Үнэлгээ хариуцсан менежерүүдийг чадавхжуулах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөө, хөтөлбөрийн зардал 9.649.000 (Есөн сая зургаан зуун дөчин есөн мянган) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний “Чадварлаг багш” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-д даалгасугай.



642311648

D:\2023 он\захирамж-2023\Захирамж-2023++.docx

Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дугаар сарын  
22-ны өдрийн 11 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт

СУРГУУЛЬД СУУРИЛСАН МЕНЕЖМЕНТИЙН  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Хөтөлбөр хэрэгжих үндэслэл:** “Хувь хүний амжилт, үндэсний өрсөлдөх чадвар, үндэсний эдийн засгийн хөгжил” – хамтын хүчин чармайлтаас ангид, улс орон бие биеэсээ хамааралтай гэдгийг умартсан, хамтдаа тогтвортой хөгжилд хүрэх, ирээдүйд “Хамтаараа тогтвортой хөгжлийг бий болгох мэдлэг, шинжлэх ухаан, инновацыг бүтээх, ингэхдээ нийгмийн, эдийн засгийн, байгаль орчны шударга ёсыг бий болгох, технологийн болон нийгмийн өөрчлөлтийн хамтын хүрээг бий болгох, боловсролын зорилгыг шинээр тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсэж байна.


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн 2.1.38 дугаар заалт, “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 2/6 тогтоол, Аймгийн засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/596 дугаар захирамжийн дагуу “Чадварлаг багш” арга хэмжээний төлөвлөгөө (2022-2024 он), Боловсрол шинжлэх ухааны сайдын “2023 оныг сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарлах тухай” А/01 дүгээр тушаал батлагдсан.

Иймд ерөнхий боловсролын сургуулийн менежментийн загвар, аргачлал, зөвлөмжийг орон нутагт түгээх, мэргэжлийн арга зүйгээр хангах, явцын хэрэгжилтэд хяналт тавих, хариу арга хэмжээ авах, сайжруулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

**Зорилго:** Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дунд суурилсан, сургууль, орон нутгийн онцлогт нийцсэн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тухайн байгууллагын менежментийн аргачлал, зөвлөмжтэй болоход чиглэнэ.

**Зорилт:** Сургуулийн менежментийн үзүүлэлт тус бүрийг сайжруулах арга зүйтэй болох, сургуулийн менежментийг сайжруулах чадавхыг бэхжүүлэх, сургуулийн менежментийг сайжруулах санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, сургалтын чанар сайжрах

**Зураглал:** Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг R-PDCA загварт суурилан боловсруулсан бөгөөд дараах зураглалын дагуу явагдана.



Энэ төлөвлөгөө нь нэг удаагийн шинжтэй бус тасралтгүй үргэлжлэх, үйл ажиллагааг тогтвортой хадгалах шинжийг агуулсан байхаар дээрх зураглалыг боловсруулсан. Сургуулийн менежментийг сайжруулахад төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалт гэсэн PDCA (Plan, Do, Check, Action) циклээр удирдах нь үр дүнтэй.

Энэ нь багш, хамт олон нэгэн цул болж нэгдмэл зорилготойгоор, сургалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн үр дүнд шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах эргэх холбоо бүхий сургуулийн менежмент юм.

**Оролцогчид:** 30 сургуулийн удирдлага, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч

**Хугацаа:** 2023 оны 02 дугаар сараас 11 дүгээр сар

**Хүрэх үр дүн:** Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна.

1. Орон нутгийн онцлогтой тухайн сургуулийн менежментийн загвар бий болж, сургуулийн удирдлага, хүний нөөцийн чадавх сайжирсан байна.

2. Сургууль, багшийн үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх, суурь түвшинд тулгуурлан зорилтот түвшинд хүрэх аргачлалыг хэрэгжүүлснээр үзүүлэлт тус бүрийн үр дүнг тодорхой хувиар ахиулсан байна.

3. Сургуулийн удирдах ажилтан, заах аргын нэгдлийн ахлагчид сургуулийн менежментийг сайжруулах үйл ажиллагааны явцад засан сайжруулах ажиглалт тэмдэглэл хийж сурсан байна.

4. Монгол хэл, бага анги, математик, байгалийн ухааны дадлага туршлагатай, тэргүүлэх багш нарыг урьж онол, арга зүйн сургалт, зөвлөн тусалж, багш нарт хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйд дэмжлэг үзүүлснээр хөтөлбөрийн хэрэгжилтийн үзүүлэлт ахисан байна.

5. Хос хэлний жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд дэмжлэг үзүүлснээр боловсролын бүх шатанд түвшин ахиулан суралцах үндсэн нөхцөл болох Монгол хэлний хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой өөрчлөлт гарсан байна.

6. Хичээл болон хичээлээс гадуурх ажилд сурагчдыг оролцуулж идэвхжүүлж, хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдын хандлага, оролцоо, сайжирсан байна.

#### Үйл ажиллагааны хөтөлбөр:

№	Үйл ажиллагаа	Агуулга	Хариуцах эзэн
<b>I шат. Сургуулийн менежментийн загвар, аргачлалыг турших, хэрэгжүүлэх</b>			
1	Сургуулийн менежментийн загвар, аргачлалыг турших, хэрэгжүүлэх	Сургуулийн менежментийг хэрэгжүүлэх хүрээнд ерөнхий боловсролын сургуультай хамтран тухайн байгууллагын онцлогт тохирсон загвар гарган ажиллах аргачлалыг боловсруулан турших, цаашид ажиллах чиглэл тодорхойлох	Л.Оюунбилэг Мэргэжилтнүүд
<b>II шат. Сургуулийн менежментийн загвар, аргачлалыг сайжруулах</b>			
2	Сургуулийн менежментийн загвар, аргачлалыг сайжруулах	Сургуулийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцан менежментийг сайжруулах чиглэлээр сургуультай хамтран ажиллах, явцын үнэлгээ хийх	М.Мөнхбат Мэргэжилтнүүд
<b>III шат. Сургуулийн сайн менежментийг тасралтгүй R-PDCA хэлбэрээр хэрэгжүүлэх</b>			
3	Сургуулийн сайн менежментийг тасралтгүй R-PDCA хэлбэрээр хэрэгжүүлэх	Сургуулийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа үр дүнд хүрсэн эсэх, менежментээ сайжруулах хэсгээ тодорхойлох, тасралтгүй R-PDCA хэлбэрээр хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө боловсруулах	Л.Оюунбилэг Мэргэжилтнүүд



Аймгийн Засаг даргын 2022 оны 17 дугаар сарын  
22-ны өдрийн 22 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

## ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЕНЕЖЕРҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

**Хөтөлбөр хэрэгжих үндэслэл:** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилгод "... улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн Монгол хүнийг хөгжүүлнэ." Хэмээн тусгасан. Энэхүү зорилгыг хөгжүүлэх хүрээнд хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Мөн боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 20230-д бага, дунд боловсролын салбарын хүрээнд дэвшүүлсэн чанар, хүртээмж, менежментийг сайжруулах хөтөлбөрт "Үнэлгээг хэрэгжүүлэх багш, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх" ажлыг тусгасан.

Энэ бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн боловсролын салбарын хүрээнд сургалтын менежерийн чиг үүрийг ялгах, үйл ажиллагаа бүр нь хэмжигдэхүйц байх үүднээс БШУ-ны Сайдын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/263 дугаар "Сургалтын менежерийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага батлах тухай" тушаалаар үндсэн чиг үүргийг тодорхой зааж өгсөн.

Иймээс аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/596 дүгээр захирамжийн дагуу "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөөнд (2022-2024 он) "Сургууль, цэцэрлэгт сургалтын арга зүй, технологи, үнэлгээний шинэчлэл"-ийн ажлыг тусгаж өгсөн.

Сургуулийн түвшинд үнэлгээ хариуцан ажиллаж буй сургалтын менежерүүдийг суралцагч, багш, сургуулийн үнэлгээний мэдлэг, ойлголт, ур чадварыг хөгжүүлэх, үнэлгээний найдвартай, хүчинтэй байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг ойлгуулж таниулах, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авах зэрэг үнэлгээний асуудлыг цогц байдлаар ойлгуулох, ач холбогдлыг таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх суурийг тавьж өгөх хэрэгцээ, шаардлага бий болж байна.

**Зорилго:** Ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ хариуцсан менежерүүдэд үнэлгээний талаарх мэдлэг, ойлголтыг эзэмшүүлэх, сургуулийн түвшинд үнэлгээ зохион байгуулах, үнэлгээний найдвартай байдлыг хангах, үр дүнг сургуулийн менежментийг хангах цогцоор нь сайжруулахад ашиглах арга зүйг эзэмшүүлэхэд оршино.

**Зорилт:**

Ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ хариуцсан менежерийг чиг үүрэг, багш, суралцааг, сургалтын байгууллагын үнэлгээний талаарх ойлголтыг нэгтгэх


Үнэлгээ төрөл, хэлбэрийг зөв ашиглах

Үнэлгээний найдвартай хүчинтэй байдлыг хангах

Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний мэдээллийг боловсруулах дүн шинжилгээ хийх чадвартай болох

Үнэлгээний үр дүнг ашиглан сургуулийн менежментийг сайжруулах арга аргачлалд суралцах

**Зураглал:** ЕБС-ийн сургалтын менежерүүдэд зориулсан чадавхжуулах хөтөлбөрийн зураглалыг R-PDCA загварт суурилан боловсруулсан.



**Оролцогчид:** 30 сургуулийн үнэлгээ хариуцсан менежерүүд

**Хугацаа:** 2023 оны 02 дугаар сараас 12 дугаар сар

**Үйл ажиллагааны хөтөлбөр:**

№	Агуулга	Хариуцах эзэн
<b>I шат Үндсэн чиг үүргийн дагуу өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгийн мэдээллийг боловсруулах</b>		
1	“Сургалтын менежерийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага батлах тухай” тушаалаар батлагдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулах	М.Мөнхбат Ажлын хэсэг
2	Сургууль, суралцагч, багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг цуглуулах, шинжилгээ хийх	Л.Оюунбилэг Ажлын хэсэг
<b>II шат Үнэлгээний найдвартай байдлыг хангах, сургуулийн менежментийг цогцоор нь сайжруулах</b>		
1	2022, 2023 оны байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд шинжилгээ хийх үр дүнд тулгуурлан сургуулийн менежментийг цогцоор нь сайжруулах зураглал гаргах, хэрэгжүүлэх	Л.Оюунбилэг Ажлын хэсэг

-----oOo-----

Аймгийн Засаг даргын шоны 11 дугаар сарын  
22-ны өдрийн 6 дугаар захирамжийн туравдугаар  
хавсралт



ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Тоо, ширхэг	Бүгд үнэ Мянган төгрөг
Нэг. Сургууль сууриссан менежментийг сайжруулах төлөвөлгөө			
1	Бичиг хэргийн зардал 9 бичгийн цаас, принтерийн хор, постор цаас)	2 боодол, А-4, цаас, 2 хор, 2 постор цаас	184.4
2	Багшийн ажлын хөлс, урамшуулал	3 удаа нэг хүний 200000	2400.0
3	Ажиллах багш, мэргэжилтний хөдөө ажиллах замын зардал	Хотоос 4 хүн 3 удаа	792,0
4	Бууцагаан явж ирэх задал	4 хүн 3 удаа	480,0
5	Сумдад ажиллах Тээвэр, шатахууны зардал	Хангай,.govийн чиглэлд 10 хүн	3151.0

Бүгд (Долоон сая зургаан мянган төгрөг ) 7006,000

Хоёр. Үнэлгээ хариуцсан сургалтын менежерийн чадавхжуулах хөтөлбөр

1	Бичиг хэргийн зардал	Постор цаас 1 боодол, бичгийн цаас 1 боодол, фламастер 5 ширхэг	93.0
2	Багийн ажлын хөлс	Нэг хүн 3 өдөр	1050.0
3	Сургалтад оролцох 30 хүний ирэх буцах зардал	2 талдаа 50000	1500.0
Бүгд (Хоёр сая зургаан дөчин турван мянган төгрөг )			2643,0
Нийт дүн: 9. 649.000 ( Есөн сая зургаан зуун дөчин есөн мянган төгрөг)			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_